



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/145-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.БҮРЭНЖАРГАЛ ТАНАА

2025.02.25 № САА - 2025/145-НА-САА-043
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 17,404.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	120,644,744.89	175,669,159.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	118,956,574.09	167,326,683.06
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	118,956,574.09	167,326,683.06
31210	Төгрөг	118,956,574.09	167,326,683.06
31211	Төрийн сангийн харилцах	118,956,574.09	167,326,683.06
35	БАРАА МАТЕРИАЛ	1,688,170.80	8,342,476.00
35400	Хангамжийн материал	1,688,170.80	8,342,476.00
35460	Хүнсний материал	1,688,170.80	6,041,576.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	2,300,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	717,645,177.83	677,796,646.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	717,645,177.83	677,796,646.43
39200	Биет хөрөнгө	500,756,927.84	460,970,896.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,665,518.05	520,665,518.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(124,324,632.48)	(148,471,152.48)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	46,958,648.64	46,958,648.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,544,386.56)	(26,900,901.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,855,391.90	36,855,391.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,207,005.35)	(14,950,961.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,786,053.00	80,786,053.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(28,475,659.36)	(34,014,700.00)
39217	Ном	43,000.00	43,000.00
39300	Биет бус хөрөнгө	216,888,249.99	216,825,750.00
39301	Програм хангамж	1,625,000.00	1,625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(368,750.01)	(431,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	215,632,000.00	215,632,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	838,289,922.72	853,465,805.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,894,340.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,894,340.02
413	Өглөг	0.00	2,894,340.02
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	2,894,340.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	838,289,922.72	850,571,465.47
51	Засгийн газрын хувь оролцоо	838,289,922.72	850,571,465.47
51100	Засгийн газрын оруулсан капитал	332,071,103.00	332,071,103.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-47,361,875.93	-35,080,333.18
51210	Өмнөх үеийн үр дүн	(47,361,875.93)	(47,361,875.93)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	12,281,542.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	553,580,695.65	553,580,695.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	838,289,922.72	853,465,805.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	996,406,737.22	1,324,959,310.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,130,870.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,130,870.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	6,170,000.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,960,870.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	986,275,867.22	1,324,959,310.98
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	933,299,600.00	1,251,768,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	933,299,600.00	1,251,768,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,976,267.22	73,190,510.98
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,976,267.22	73,190,510.98
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	936,760,940.08	1,312,677,768.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	936,760,940.08	1,312,677,768.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	923,248,040.08	1,301,366,668.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,013,094.13	905,250,636.70
210101	Үндсэн цалин	375,752,147.42	538,217,190.25
210102	Нэмэгдэл	196,074,592.81	338,073,001.45
210104	Урамшуулал	16,186,353.90	28,960,445.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,625,228.87	112,854,460.35
210201	Тэтгэврийн даатгал	53,384,073.87	80,067,445.71
210202	Тэтгэмжийн даатгал	6,280,573.37	9,079,218.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,088,821.56	4,647,807.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,184,560.11	3,847,295.60
210205	Эрүүл мэндийн даатгал	11,687,199.96	15,212,693.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,325,967.22	54,646,510.98
210301	Гэрэл, цахилгаан	7,731,044.03	8,198,164.15
210302	Түлш, халаалт	31,308,554.19	33,524,875.01
210303	Цэвэр, бохир ус	8,286,369.00	12,923,471.82
2104	Хангамж, бараа материалын зардал	20,145,888.00	0.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,145,888.00	0.00
2105	Нормативт зардал	105,778,604.40	123,257,228.80
210502	Хоол, хүнс	105,778,604.40	123,257,228.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,650,300.00	18,544,000.00
210604	Урсгал засвар	5,650,300.00	18,544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	3,744,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,744,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,708,957.46	83,068,931.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,054,570.00	32,276,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,236,700.00	10,944,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,417,687.46	39,848,531.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,512,900.00	11,311,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,512,900.00	11,311,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,512,900.00	11,311,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	59,645,797.14	12,281,542.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	59,645,797.14	12,281,542.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	986,275,867.22	1,324,959,310.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	986,275,867.22	1,324,959,310.98
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	933,299,600.00	1,251,768,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	933,299,600.00	1,251,768,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,976,267.22	73,190,510.98
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,976,267.22	73,190,510.98
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	875,924,665.42	1,276,589,202.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	875,924,665.42	1,276,589,202.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,411,765.42	1,265,278,102.01

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,013,094.13	905,250,636.70
210101	Үндсэн цалин	375,752,147.42	538,217,190.25
210102	Нэмэгдэл	196,074,592.81	338,073,001.45
210104	Урамшуулал	16,186,353.90	28,960,445.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,625,228.87	109,960,120.33
210201	Тэтгэврийн даатгал	53,384,073.87	77,173,105.69
210202	Тэтгэмжийн даатгал	6,280,573.37	9,079,218.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,088,821.56	4,647,807.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,184,560.11	3,847,295.60
210205	Эрүүл мэндийн даатгал	11,687,199.96	15,212,693.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,325,967.22	54,646,510.98
210301	Гэрэл, цахилгаан	7,731,044.03	8,198,164.15
210302	Түлш, халаалт	31,308,554.19	33,524,875.01
210303	Цэвэр, бохир ус	8,286,369.00	12,923,471.82
2105	Нормативт зардал	107,466,775.20	127,610,634.00
210502	Хоол, хүнс	107,466,775.20	127,610,634.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,650,300.00	18,544,000.00
210604	Урсгал засвар	5,650,300.00	18,544,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,307,600.00	8,744,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,307,600.00	3,744,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,022,800.00	40,521,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,786,100.00	29,577,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,236,700.00	10,944,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,512,900.00	11,311,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,512,900.00	11,311,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,512,900.00	11,311,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	110,351,201.80	48,370,108.97
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,276,200.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,276,200.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,276,200.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	7,276,200.00	0.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,276,200.00)	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	103,075,001.80	48,370,108.97
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	118,956,574.09
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	167,326,683.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-47,361,875.93	838,289,922.72
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	12,281,542.75	12,281,542.75
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-35,080,333.18	850,571,465.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,324,959,310.98	1,276,589,202.01	48,370,108.97	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,324,959,310.98	1,276,589,202.01	48,370,108.97	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,313,648,210.98	1,265,278,102.01	48,370,108.97	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	918,151,700.00	905,250,636.70	12,901,063.30	98.6
210101	Үндсэн цалин	554,184,800.00	538,217,190.25	15,967,609.75	97.1
210102	Нэмэгдэл	343,178,900.00	338,073,001.45	5,105,898.55	98.5
210104	Урамшуулал	20,788,000.00	28,960,445.00	(8,172,445.00)	139.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,763,100.00	109,960,120.33	14,802,979.67	88.1
210201	Тэтгэврийн даатгал	81,599,900.00	77,173,105.69	4,426,794.31	94.6
210202	Тэтгэмжийн даатгал	9,590,100.00	9,079,218.34	510,881.66	94.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,796,100.00	4,647,807.18	148,292.82	96.9
210204	Ажилгүйдлийн даатгал	4,796,100.00	3,847,295.60	948,804.40	80.2

210205	Эрүүл мэндийн даатгал	23,980,900.00	15,212,693.52	8,768,206.48	63.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,646,510.98	54,646,510.98	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,198,164.15	8,198,164.15	0.00	100.0
210302	Түлш, халаалт	33,524,875.01	33,524,875.01	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	12,923,471.82	12,923,471.82	0.00	100.0
2105	Нормативт зардал	147,131,600.00	127,610,634.00	19,520,966.00	86.7
210502	Хоол, хүнс	147,131,600.00	127,610,634.00	19,520,966.00	86.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,544,000.00	18,544,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	18,544,000.00	18,544,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	8,744,900.00	(3,744,900.00)	174.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	3,744,900.00	(3,744,900.00)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,411,300.00	40,521,300.00	4,890,000.00	89.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,467,000.00	29,577,000.00	4,890,000.00	85.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,944,300.00	10,944,300.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,311,100.00	11,311,100.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,311,100.00	11,311,100.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,311,100.00	11,311,100.00	0.00	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,324,959,310.98	1,324,959,310.98	0.00	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,251,768,800.00	1,251,768,800.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,251,768,800.00	1,251,768,800.00	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,190,510.98	73,190,510.98	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		118,956,574.09	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		167,326,683.06	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Суралцахуйн таатай, тохилог, эко орчинг бүрдүүлэн хамтын ажиллагаатай байж хүүхдийн хөгжил төлөвшилд ахиц, үр дүн гаргана” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг судлагдахуун бүрээр чанартай зохион байгуулж хүүхдийн хөгжлийг дэмжих
- Цэцэрлэгийн үйл ажиллагааг өдрийн дэглэмийн дагуу явуулж хүүхдийн ялгаатай хэрэгцээтэй онцлогт тохируулан чадвар олгох
- Цэцэрлэгийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, сумын болон багийн хамтарсан багтай хамтран ажиллах
- Сум орон нутгийн болон эцэг эх асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр хүүхдийн сургалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих
- Хүүхдийн хоол хүнсний илчлэг норм нормативыг баримтлан байгалийн жимс жимсгэнээр хангах, “Өдөр бүр сүү” арга хэмжээг хэрэгжүүлэх хүүхдийн дархлааг дэмжин эрүүлжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,175.8 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	118,956.6	167,326.7	48,370.1
Авлага			
Бараа материал	1,688.2	8,342.4	6,654.2
Үндсэн хөрөнгө	717,645.2	677,796.7	(39,848.5)
Нийт хөрөнгө	838,290.0	853,465.8	15,175.8
Өр төлбөр	-	2,894.3	2,894.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	838,290.0	850,571.5	12,281.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	838,290.0	853,465.8	15,175.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 167,326.7 мянган төгрөг болж 48,370.1 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 8,342.4 мянган төгрөг болж 6,654.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 170,342.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 163,687.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд 853,465.8 мянган төгрөг болж 39,848.5 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал байгуулснаас,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 2,894.3 мянган төгрөгөөр өссөн нь цалингаас суутгасан НДШ-ийг дутуу шилжүүлснээс тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 985,623.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 93,430.4 мянган төгрөг, нийт 1,079,053.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 114,069.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 56,749.2 мянган бараа үйлчилгээний бусад зардлыг 7,973.9 мянган төгрөгөөр нийт 64,723.1 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 1,128,400.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,284.2 мянган төгрөгөөр, цалин, НДШ-ийн зардлыг 205,142.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 10,373.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 216,799.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 20,239.9 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,132,812.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 73,190.5 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 118,956.6 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт 1,324,959.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,324,959.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,276,589.2 мянган төгрөгийг зарцуулж, 48,370.1 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,276,589.2 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 30,035.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 18,334.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801- Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,525.6	2,445.0	80.6	96.8
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	157,646.4	127,610.6	30,035.8	80.9
		3	80233- Хүүхэд хамгаалал	1,660.5	1,660.5	-	100.0
		4	81816- Зөв монгол хүүхэд	4,700.9	4,700.9	-	100.0
		5	81823- Боловсролын багшийн сургалт	2,903.2	900.0	2,003.2	31.0
		6	81834- Боловсролын стандарт сургалт	1,058,943.3	1,045,869.0	13,074.3	98.8

	7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	18,388.9	15,212.7	3,176.2	82.7
	8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	73,190.5	73,190.5	-	100.0
	9	83603-Нэмэлт санхүүжилт	5,000.0	5,000.0	-	100.0
		Нийт дүн	1,324,959.3	1,276,589.2	48,370.1	96.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 106,457.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 1 удаа зарласан боловч оролцогч ирээгүйгээс “Мандал Минерал” ХХК, “Шанзан ташуур” ХХК, “Мөнх Би То Са” ХХК, “Тулга Өргөжих” ХХК,-иудтай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ний Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 936,760.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,367.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 1 цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу ил тод нээлттэй зохион байгуулж байх 1 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 22,279.8 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайланд 2,894.3 мянган төгрөгийн өр төлбөр тусгаагүй,
- Нийгмийн даатгалын тайланд багш, ажиллагсдын 19,385.5 мянган төгрөгийн амралтын цалинг тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь

“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **4,781.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **1,886.9** мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, **2,894.3** мянган төгрөгийн 1 албан шаардлага зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тухайн төсвийн дээд шатны захирагчийн шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаарын сарын 01-ний өдрийн 01/86 дугаар захирамжаар нягтлан бодогч С.Оюун-Эрдэнэ, нярав Г.Гандиймаа нарын үндсэн цалинг 25 хувиар нэмэгдүүлэн 1,740.6 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь *“Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3: “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”,* Засгийн газрын 2024 оны *“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”* 128 дугаар тогтоолын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Нягтлан бодогч С.Оюун-Эрдэнэд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг **146.3** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 20.2.5 дахь 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,894.3** мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”,* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Зайлшгүй шаардлагын улмаас цэцэрлэгийн орон тоонд батлагдаагүй бичиг хэргийн ажлыг хавсарсан гэх үндэслэлээр нягтлан бодогч С.Оюун-Эрдэнэд нэмэгдэл цалин хөлс олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалын тайланд цалин дутуу тайлагнасан	1	19,385.5	1	19,385.5			1	19,385.5				
Санхүүгийн тайланд өглөг тусгаагүй	1	2,894.3	1	2,894.3			1	2,894.3				
Дүн	2	22,279.8	2	22,279.8			2	22,279.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

					0					
Цалин илүү олгосон	1	1,740.6	1	1,740.6						
Цалин илүү олгосон	1	146.3	1	146.3						
Өр төлбөр үүсгэсэн	1	2,894.3			1	2,894.3				
Батлагдаагүй орон тоог хавсран гүйцэтгүүлсэн	1						1			
Дүн	4	4,781.2	2	1,886.9	1	2,894.3	1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.